

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ДОЛЛАРЖИЛТ

Судалгааны хэлтсийн эдийн засагч Д.Энхзаяа

Хураангуй

Энэ судалгааны ажлаар Монгол улсын долларжилтын шалтгаан болон үр дагаврыг тодорхойлохыг зорьсон. Долларжилтын түвшинг тодорхойлохдоо банкны систем дэх гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгө, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаагаар илэрхийлэх буюу “санхүүгийн долларжилт”-ыг судаллаа. Судалгаанд 2000 оны 1-р сараас 2010 оны 3-р сар хүртэлх тоон өгөгийг сарын давтамжтайгаар, вектор алдаа залруулах загвар (VECM), 2 алхамт хамгийн бага квадратын арга (TSL) ашиглан эмпирик шинжилгээ хийсэн бөгөөд үр дүн онолын таамаглалтай нийцтэй гарсан. Судалгааны үр дүнгээс харахад манай улсын долларжих үйл явц нь бусад хөгжиж буй орнуудын адилаар макро эдийн засгийн тогтворгүй байдал (инфляци болон бодит ханшийн өөрчлөлтийн харьцангуй хэлбэлзлээс хамаарна) , зах зээлийн гажуудал болон институцийн чанараас хамаардаг бөгөөд долларжилт өсвөл санхүүгийн системийн эмзэг байдал нэмэгддэг байна. Харин долларжилт нь зөвхөн өндөр инфляцитай үед л санхүүгийн зуучлалын гүнзгийрэлд эерэг нөлөөлж байна.

1. ОРШИЛ

Мөнгөний үндсэн гурван үүрэг болох өртөг хэмжих, арилжаа хийх, баялаг хуримтлуулах зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтийн оронд гадаад валютыг өргөн ашиглаж байгаа үзэгдлийг долларжилт гэж ойлгоно.

Өнгөрсөн хориод жилийн турш олон улсын санхүүгийн системийн интегралчлал, институцийн өөрчлөлт, хөрөнгийн урсгалын либералчлал зэрэгтэй холбоотойгоор долларжих үзэгдэл өргөн ажиглагдаж байна. 1990-ээд оны үед гадаад валютыг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл болгосон орнуудын тоо өсч, албан долларжилтын асуудал анхаарал татаж байсан бол сүүлийн жилүүдэд албан бус долларжилт илүү өргөн хүрээг хамарсан үзэгдэл болоод байна. Зөвхөн Латин Америк төдийгүй нэлээд олон хөгжиж буй оронд банкны систем дэх гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгө нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 30-70 хувийг¹ эзэлж, долларжилт өндөр түвшинд хүрч байна. Үүний адилаар, Монгол улсад өнгөрсөн арваад жилийн турш албан бус долларжих үйл явц мөн ажиглагдаж байна.

Төв банк яагаад долларжилтанд анхаарлаа хандуулах шаардлагатай вэ? Үүний хамгийн чухал шалтгаан бол долларжилт *санхүүгийн системийн тогтвортой байдал* болон Төв банкны *мөнгөний бодлого удирдах чадварт* нөлөөлдөгтэй холбоотой юм. Хэрэв санхүүгийн системийн ихээхэн хэсэг нь гадаад валютаар илэрхийлэгдэж байвал хөрвөх чадварын болон төлбөрийн чадварын эрсдэл бий болдог. Мөн өндөр долларжилттай эдийн засагт мөнгөний эрэлт тогтворгүй, гадаад шоконд үнийн мэдрэмж их байдаг учраас мөнгөний бодлогын үр ашгийг бууруулж, Төв банкны эдийн засагт нөлөөлөх чадварыг хязгаарладаг.

Долларжилт нь ерөнхийдөө инфляци болон валютын ханшийн сулралтаас үүдэж дотоод валютын үнэ цэнэ муудсаны үр дүнд бий болдог. Монгол улс санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор 2008-2009 онд инфляци болон валютын ханшийн өндөр хэлбэлзэлтэй байсан нь үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл бууруулж, долларжилтыг өсгөх нөхцлийг бүрдүүлж байсан. Гэсэн хэдий ч долларжилт зөвхөн макро эдийн засгийн тогтворгүй байдлаас гадна банк, санхүүгийн хуулийн орчин, институцийн чанар, зах зээлийн гажуудал зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч болно. Иймд долларжилтын шалтгаан болон үр дагаврыг ойлгох нь цаашдын бодлогыг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Энэхүү судалгаагаар Монгол улсын долларжих үйл явц ба түүний эдийн засагт үзүүлэх нөлөөг тодорхойлохыг зорьсон. Уг зорилгын хүрээнд дараах гурван үндсэн асуултанд хариулах зорилт тавьсан. Үүнд: i). Долларжилтыг ямар хүчин зүйс тодорхойлдог, тэдгээрийн хооронд урт хугацааны хамаарал байгаа эсэх, ii). Долларжилт санхүүгийн зуучлалын гүнзгийрлийг дэмждэг эсэх, iii). Долларжилт нь санхүүгийн системийн тогтворгүй, эмзэг байдлыг бий болгоход нөлөөлдөг эсэх.

Эмпирик шинжилгээг 2000 оны 1-р сараас 2010 оны 3-р сар хүртэлх тоон өгөглийг сарын давтамжтайгаар, Вектор алдаа залруулах загвар, 2 алхамт хамгийн бага квадратын арга ашиглан хийсэн бөгөөд судалгааны үр дүн онолын таамаглалтай нийцтэй гарлаа.

Судалгааны 2-р хэсэгт долларжилтын талаар хийгдсэн гол судалгаануудын товч тайлан, 3-р хэсэгт онолын үндэслэлийг гаргах бөгөөд 4-р хэсэгт Монгол улс дахь

¹ José M. Cartas, IMF's Statistics Department, march 2010 pp

долларжилтын байдлыг тодорхойлон, 5-р хэсэгт эмпирик шинжилгээг хийж, эцэст нь дүгнэлт танилцуулах болно.

2. СУДАЛГААНУУДЫН ТОЙМ

Долларжилтын талаарх судалгаа онолын болон эмпирик түвшинд олон чиглэлээр хийгдсэн байдаг. Ихэнх судалгаа нь “санхүүгийн долларжилт”²-ыг тодорхойлох хүчин зүйлсийг судлахад чиглэсэн бөгөөд дотоод, гадаад валютаар илэрхийлэгдэх активын бодит өгөөжийн харьцангуй түвшнээр долларжих үйл явцыг тайлбарласан байдаг. Тухайлбал:

Irfan Civeir (2000) Туркийн эдийн засаг дахь долларжилтыг судлахдаа дотоод, гадаад валютаар илэрхийлэгдэх активын өгөөжийн бодит түвшин, валютын ханшийн хүлээгдэж буй өөрчлөлт, ханшийн эрсдэл, эдийн засгийн бодлогод итгэх итгэл зэргийг төлөөлөх хувьсагчдыг загварт оруулж коинтеграци хамаарлыг шалгасан бөгөөд судалгааны үр дүнд дотоод, гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү Туркийн долларжилтыг тодорхойлох гол хувьсагч болохыг харуулсан.

Alina Luca, Iva Petrova (2003) шилжилтийн эдийн засаг дах зээлийн долларжилтанд³ банк болон пүүсийн аль нь илүү нөлөөлж байгааг 21 шилжилтийн эдийн засагтай орны тоон мэдээллийг ашиглан судалсан. Судалгааны үр дүнгээс харахад банкуудын тэнцэлд ханшийн тэнцвэргүй байдал үүсэх нь⁴ зээлийн долларжилтыг тодорхойлох гол хүчин зүйл болдог байна. Мөн санхүүгийн долларжилт (банк) нь бодит долларжилт (пүүс)-ын шалтгаан болохыг харуулсан. Өөрөөр хэлбэл, банк ханшийн эрсдэлээ аж ахуйн нэгжүүдэд шилжүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Харин зарим хөгжиж буй орнуудад инфляци болон валютын ханш тогтворжсон ч санхүүгийн долларжилт өссөн хэвээр байсан нь судлаачдыг өөр тайлбар хайхад хүргэсэн бөгөөд сонирхлын гажуудал, институцийн онол зэрэгтэй холбож тайлбарлах болсон. Тухайлбал, Gianni De Nicolo, Patrick Honohan, Alain Ize (IMF, 2003) нар хөгжингүй болон хөгжиж буй 100 орны түүврийг ашигласан судалгаандаа мөнгөний бодлогын итгэл үнэмшил болон институцийн чанар долларжилтанд нөлөөлөх гол хүчин зүйлс болохыг тодорхойлсон бөгөөд өндөр долларжилттай санхүүгийн систем илүү тогтворгүй болдгийг харуулсан байдаг.

De Nicolo et al (2003)-ын судалгаагаар өндөр долларжилттай банкны системд төлбөрийн чадварын болон хөрвөх чадварын эрсдэл нэмэгддэг болохыг нотолсон байна. Мөн Arteta (2003) санхүүгийн долларжилт нь банкны хямрал тохиолдох магадлалыг өсгөж байгааг харуулсан байдаг.

Эмпирик судалгаануудаас харахад, хөгжиж буй орнуудад долларжилт нь ихэвчлэн өндөр, тогтворгүй инфляци болон валютын ханшийн сулралтаас шалтгаалдаг бөгөөд эдийн засагт долларжилтын түвшин өндөр байх тусам гадаад шоконд өртөмтгий, эмзэг байдгийг харуулж байна.

² Банкны систем дэхь актив, пассивын тодорхой хэсэг нь гадаад валютаар илэрхийлэгдэнэ.

³ Гадаад валютаар олгосон зээлийн нийт зээлд эзлэх хувиар илэрхийлэгдэнэ.

⁴ Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө, зээл өөр валютуудаар илэрхийлэгдэх үед авлага, өглөг өөр валютаар илэрхийлсэн гэрээтэй учраас ханшийн эрсдэл үүсдэг.

3. ОНОЛЫН ХЭСЭГ

Энэ хэсэгт долларжилтын талаарх тодорхойлолт, түүнийг хэрхэн хэмжих, долларжилт үүсэх шалтгаан болон үр дагаврыг тайлбарладаг онолуудын талаар тайлбарлав.

3.1. Долларжилт, түүний хэлбэрүүд

Мөнгөний үндсэн гурван үүрэг болох өртөг хэмжих, арилжаа хийх, баялаг хуримтлуулах зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтийн оронд гадаад валютыг өргөн ашиглаж байгаа үзэгдлийг долларжилт гэж ойлгоно. Долларжилтын түвшинг тодорхойлох нэг үзүүлэлт нь банкны систем дэх гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгө, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаагаар илэрхийлэгддэг.

Хуулинд албан ёсоор зөвшөөрөгдсөн эсэхээс хамааран долларжилтыг дараах төрөлд ангилдаг. Үүнд:

- *Албан долларжилт*: Засгийн газар аль нэгэн гадаад валютыг хууль ёсны мөнгөн тэмдэгт болгон хэрэглэдэг.
- *Хагас албан долларжилт*: Гадаад валютыг төлбөр тооцооны хэрэгсэл болгохыг хуулиар зөвшөөрдөг боловч цалин, татвар болон өдөр тутмын зардалд дотоод валют хоёрдогч үүрэгтэй байна.
- *Албан бус долларжилт*: Гадаад валютыг хуулиар хэрэглэхийг зөвшөөрөөгүй боловч цалин, татвар болон өдөр тутмын зардал дотоод валютаар илэрхийлэгдэж, харин орон сууц, автомашин зэрэг өндөр үнэтэй, үл хөдлөх хөрөнгүүд ихэвчлэн гадаад валютаар төлөгддөг.

Долларжилтын үйл явц нь тодорхой үе шатаар гүнзгийрдэг.

- Нэгдүгээр шатанд, “*Активын орлуулалт*”- дотоодын мөнгөн тэмдэгт хуримтлалын үүргээ алддаг.
- Хоёрдугаар шатанд, “*Мөнгөн тэмдэгтийн орлуулалт*” - дотоодын мөнгөн тэмдэгт өртгийн хэмжүүр болон арилжааны хэрэгсэл болох үүргээ алддаг.

Долларжилт нь дараах хэлбэрээр ажиглагддаг.

- *Төлбөрийн долларжилт* - өдөр тутмын арилжаанд гадаад валют хэрэглэгддэг.
- *Бодит долларжилт* - үнэ ба цалин гадаад валютаар илэрхийлэгддэг.
- *Санхүүгийн долларжилт* – банкны систем дэхь актив ба пассив гадаад валютаар илэрхийлэгддэг.

Долларжилтын дээрх хэлбэрүүд дотроос “**санхүүгийн долларжилт**” нь илүү өргөн хүрээтэй бөгөөд сүүлийн жилүүдэд хөгжиж буй орнуудад нийтлэг тохиолдож байна. Иймээс уг судалгаанд санхүүгийн долларжилтыг судалсан болно.

3.2. Долларжилтыг тайлбарлах онол, таамаглал

Долларжих үзэгдлийг тайлбарладаг дараах онолын үндэслэлүүд байдаг.

Багцын онол

Портфелийн онолоор эрсдэлд дургүй хэрэглэгч урт хугацаанд илүү тогтвортой байх валютаар хадгаламж хийдэг буюу өөрийн портфелийн өгөөжийн хэлбэлзлийг хамгийн бага байлгах аар валютын бүрэлдэхүүнээ сонгодог гэж үздэг.

Багц сонголтын загвар (Ize ба Levy Yeyati, 2003)

Эрсдэлд дургүй хэрэглэгч төгрөгийн ба долларын хадгаламж гэсэн 2 сонголттой хөрөнгө оруулалтын цэснээс сонголтгоо хийдэг гэж үзье. Төгрөгийн бодит өгөөжинд инфляцийн түвшин, долларын бодит өгөөжинд бодит ханшийн өөрчлөлт нөлөөлнө.

Хэрэглэгч дараах ханамжийн функцийг хамгийн их байлгах сонголт хийнэ.

$$\max_{x_j} U = E(r) - \text{Var}(r)/2 \quad [1]$$

Энд, $x_j \geq 0$, $j = t, d$ - нийт багц дах төгрөг, долларын эзлэх хувь, $r = \sum_j x_j r_j$ - багцын бодит өгөөж.

Энэ тэгшитгэл нь эрсдэлд дургүй хэрэглэгч хүлээгдэж буй өгөөжийн түвшинд нийт өгөөжийн хэлбэлзлийг хамгийн бага байлгах багцыг сонгох нь ханамжийг хамгийн их байлгана гэдгийг харуулж байна. Хүүний паритет нөхцөл (UIP) хангагддаг гэж үзвэл өгөөжийн хэлбэлзэл хамгийн бага байх оновчтой хөрөнгө оруулалтын багц дах долларын эзлэх хувь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ. (*mvp*-хамгийн бага хэлбэлзэлтэй портфель)

$$mvp \equiv ((\text{var}(\pi) + \text{cov}(\pi, s))/(\text{var}(\pi) + \text{var}(s) + 2\text{cov}(\pi, s)) \quad [2]$$

(Техникийн тооцооллыг хавсралт 1.1-ээс харна уу.)

$\mu_s \approx \mu_e - \mu_\pi$ (e - нэрлэсэн ханшийн өөрчлөлт) гэж үзэн татан төвлөрүүлсэн хөрөнгийн долларжилтын харьцааг хялбарчилбал:

$$mvp = \text{var}(\pi)/\text{cov}(\pi, e) \quad [3]$$

Эндээс долларжилт ханшийн мэдрэмжийн коэффициенттой шууд пропорциональ хамааралтай байна.

Загварын тайлбар:

MVP буюу хамгийн бага хэлбэлзэлтэй багц сонголтын онолын дагуу санхүүгийн долларжилтын түвшин нь инфляци, бодит ханшийн өөрчлөлтийн харьцангуй хэлбэлзлээс хамаарч байна. Инфляцийн хэлбэлзэл бодит ханшийн өөрчлөлтийн хэлбэлзэлтэй харьцуулахад өндөр байвал төгрөгийн актив эрсдэлтэй болох учраас долларыг илүүд үзнэ. Өөрөөр хэлбэл, долларын хадгаламжийн хүү төгрөгийн хүүнээс илүү тогтвортой байвал доллараар хадгалах сонирхолтой болно. Эсрэгээр, инфляци буурсан ч бодит ханшийн хэлбэлзэл инфляцийн хэлбэлзэлтэй адилхан юм уу түүнээс илүү хэмжээгээр буурч байвал долларжилт буурахгүй байх магадлалтай юм.

Иймд бидний загварын таамаглалд *mvp* хувьсагч өсөх тусам долларжилт өснө гэж таамаглаж байна.

Зах зээлийн гажуудал, сонирхлын гажуудал

Долларжилтанд нөлөөлөх нэг гол хүчин зүйл нь зах зээлийн гажуудалтай холбоотой юм. Зах зээлийн гажуудал нь ихэвчлэн төгс бус мэдээлэл, өрсөлдөөнт бус зах зээл, дам нөлөөтэй холбоотой бөгөөд зээлийн болон даатгалын зах зээл байхгүй, зах зээлийн механизмын сул хөгжлөөс шалтгаалдаг. Мөн зах зээлийн гажуудал, хадгаламжийн даатгал болон зээлдэгчийн баталгаа зэрэгтэй холбоотойгоор сонирхлын гажуудал (*морал хазард*) үүсэх тохиолдол байдаг. Энэ тохиолдолд санхүүгийн долларжилт нь эдийн засгийн тухайн нөхцөл байдалд агентуудын оновчтой хариу үйлдэл үзүүлж буй үр дагавар гэж үздэг.

Зах зээлийн гажуудлын үзлээр долларжилт хэрхэн өсч болохыг дараах байдлаар тайлбарлая: Энэ нь өр төлөгдөхгүй байх /дампуурах/ магадлал, валютын ханш хоорондоо эерэг хамааралтай бөгөөд зээлдүүлэгч нь зээлдэгчийн нийт өрийн валютын бүрэлдэхүүний талаар төгс бус мэдээлэлтэй гэсэн 2 үндсэн нөхцөлтэй байна.

Загвар (Broda and Levy Yeyati, 2003)

Хөрөнгө оруулагч pR (p -дотоод үнийн индекс)- өгөөжтэй төслийг зээлээр санхүүжүүлдэг гэж үзье. Зээлдүүлэгчид нь эрсдэлд нейтраль, зээлдэгч нь хязгаарлагдмал өртэй байна. Зээлийн хугацааны эцэст төгрөгийн доллартай харьцах ханш $e \in \{e^l, e^h\}$ байна. Энд, $e^l < p(e^l) < 1 < p(e^l) < e^h$ p , $prob(e = e^l) = q$ одоогийн ханшийн түвшинг 1-тэй нормчилна.

Гол таамаглал нь төгрөгийн ханш сулрах тусам зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал өсдөг гэж үзнэ. Хэрэв өр төлөгдөхгүй болсон тохиолдолд зээлдэгчийн үлдсэн хөрөнгө $(1 - \theta)p(e^l)R$ -ийг зээлдүүлэгчид өөрсдийн авлагын $\delta(\lambda) = (1 - \theta)p(e^l)R / [(1 - \lambda)r_t + \lambda e^h r_d]$ - хэсгээр хувь тэнцүүлэн хувааж авна. Энд, θ - өр барагдуулах зардал/, λ - зээлдэгчийн нийт өрөнд долларын эзлэх хувь, r_t ба r_d - төгрөг, долларын зээлийн хүү.

Төгрөг, долларын зээлийн хүүний хувьд арбитраж хийх нөхцөл хангагдвал:

$r_t[q + (1 - q)\delta] = r_d[qe^l + (1 - q)\delta e^h]$, эндээс дараах илэрхийллийг гаргаж авна.

$$s \equiv (r_t - e^l r_d) = e^l(1 - q)\delta(e^h - e^l) / [q + (1 - q)\delta] > 0 \quad [4]$$

S - ханш унаж, өр төлөгдөхгүй болсон тохиолдолд хүүгийн арбитражийн дагуу төгрөгөөр зээлдүүлэгчид шаардагдагдах нэмэгдэл өгөөжийг илэрхийлнэ.

Хэрэв зээлдэгчийн нийт өрийн валютын бүрэлдэхүүнийг зээлдүүлэгч мэдэхгүй бол зээлдэгч ашгаа хамгийн их байлгах тэгшитгэл нь:

$$\max_{\lambda} = [q/p(e^l)][p(e^l)R - (1 - \lambda)r_t - \lambda e^l r_d] \quad [5]$$

$$\pi = [q/p(e^l)]s > 0$$

Эндээс, зээлдэгч ($\lambda = 1$) долларын зээлийг сонговол ашиг хамгийн их байх болно. Тухайн тохиолдолд, хэрэв хадгаламжийн даатгалтай үед $\delta_i > \delta$ учраас долларжилтыг өсгөнө. δ нь θ -өөс сөрөг хамааралтай тул зээлдүүлэгчийн эрхийн хамгаалалт мөн долларжилтыг өсгөж болохыг харуулж байна.

Загварын тайлбар:

Зээлдүүлэгчийн хувьд, өр төлөгдөхгүй болсон тохиолдолд долларын зээлдүүлэгчид ашигтай, харин дампуураагүй тохиолдолд төгрөгийн зээлдүүлэгчид төгрөгийн нэмэлт эрсдэлийн төлбөр шаардлагатай учраас зээлдэгчид долларын зээл олгох илүү сонирхолтой болно. Иймд ерөнхий тэнцвэрт, зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийн тал хоёулаа долларын зээлийг илүүд үзэх буюу долларжилтын өндөр түвшинд тэнцвэр тогтож байна гэсэн үг юм.

Институцийн чанар, бодлогын нэр хүнд

Албан бус долларжилтыг институцийн эдийн засгийн онолоор тайлбарладаг. Хуулийн болон төрийн институцийн чанар муу, санхүүгийн зах зээлийн хөгжил сул байх нь долларжилт үүсэх үндсэн хөшүүрэг болдог. Үүнээс үүдэн морал хазартын⁵ асуудал гарч ирдэг бөгөөд энэ нь эргээд гадаад валютын эрэлтийг ихэсгэх үр дагавартай. Мөн санхүүгийн зах зээлийн сул хөгжилтэй улсад дотоод валютаар урт хугацааны зээл авах нөхцөл, боломжгүй учраас гадаад валютын зээл өсөх магадлалтай байдаг.

Эдийн засгийн бодлогын итгэл үнэмшил сулрах нь долларжилтыг өсгөхөд нөлөөлнө. Тухайлбал, мөнгөний бодлого итгэл үнэмшилгүй, тодорхой бус байх нь дотоод валютын өрийн зардлыг өсгөж, өр хугацаандаа төлөгдөхгүй байх магадлал өсдөг. Энэ тохиолдолд санхүүгийн гэрээнд дотоод валютыг хэрэглэхээс зайлсхийж, доллараар индексжсөн өрийг үр ашигтай арга хэрэгслээр сонгоход хүрдэг. Ерөнхийдөө, инфляци өндөр байх нь дотоод валютад итгэх итгэлийг бууруулснаар дотоод валютын татан төвлөрүүлсэн хөрөнгө болон зээлийг гадаад валютаар илэрхийлэх шалтгаан болдог. Харин Төв банкны эзэмшиж буй гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ их байх нь дотоод валютанд итгэх итгэл өндөр, мөнгөний бодлого тогтвортой байх дохио болдог учраас долларжилтанд сөрөг нөлөөтэй байна.

3.3. Долларжилтын үр дагавар

Санхүүгийн системийн тогтворгүй байдал

- *Хувийн секторын* хувьд санхүүгийн систем болон аж ахуйн нэгжүүдийн тэнцэл нь их хэмжээгээр доллараар илэрхийлэгдэж байвал ханшийн тэнцвэргүй байдлын улмаас төлбөрийн чадварын эрсдэлд хүргэдэг. Банк дотоод валютаар орлого олдог пүүст гадаад валютаар зээл олгодог учраас санхүүгийн болон бодит секторын эрсдэл харилцан хамааралтай байдаг. Иймд санхүүгийн долларжилт өсөх нь нийт эдийн засаг шоконд илүү өртөмтгий, эмзэг болох сөрөг үр дагавартай. Мөн түүнчлэн өндөр долларжилттай эдийн засагт дотоод валютын ханш сулрана гэсэн хүлээлттэй үед пүүсүүд үнээ түүнд тохируулж өөрчилдөг. Тиймээс долларжилт пүүсийн үнэ тодорхойлох чадварыг сулруулж, валютын ханшийн үнэнд үзүүлэх нөлөөг ихэсгэхэд хүргэдэг.
- *Харин улсын секторын* хувьд засгийн газрын өрийн тогтвортой байдалд долларжилт ихээхэн нөлөөлдөг. Орлого дотоод валютаар илэрхийлэгдэж

⁵ Тухайлбал, засгийн газар ханшийн эрсдэлээс хамгаалсан ямар нэг баталгаа гаргасан тохиолдолд зээлдэгч ханшийн эрсдэлийг бүрэн шингээдэггүй бөгөөд доллараар зээл авах нь урт хугацаандаа ашигтай байдаг.

байхад өрийн дийлэнх хэсэг доллараар илэрхийгдэж байвал засгийн газрын төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлнө. Иймээс өрийн долларжилт өндөр түвшинд байгаа үед бодит ханшийн хэлбэлзэл өрийн дарамтыг ихэсгэснээр төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Цаашилбал, банкны систем засгийн газраас их хэмжээний авлагатай үед банкны системийн төлбөрийн чадварт шууд нөлөөлдөг.

Мөнгөний бодлогын бие даасан байдал

- Өндөр долларжилттай эдийн засагт мөнгөний эрэлт тогтворгүй, валютын ханшийн үнэнд үзүүлэх нөлөө ихсэх учраас мөнгөний бодлогын арга хэрэгслээр инфляцид нөлөөлөх чадварыг бууруулдаг.
- Төв банкны эцсийн зээлдүүлэгчийн үүргийг хязгаарладаг. Төв банкнаас арилжааны банкуудад төлбөрийн чадварын эрсдэл тохиолдсон үед зээл олгодог. Хэрэв долларжилтын түвшин өндөр байвал мөнгө хэвлэх нь урт хугацаанд хөрвөх чадварыг хангаж чаддаггүй бөгөөд гаднаас зээл авах зэрэг өөр эх үүсвэр хайх хэрэгтэй болдог.
- Албан бус долларжилттай эдийн засагт зээлийн тасалдал (credit crunch) үүсэх магадлал өндөр байдаг. Дотоод валютын ханш суларвал зээлийн барьцааны долларын үнэ цэнийг бууруулдаг бөгөөд долларын зээлийн эргэн төлөлт хоцрох эрсдэлийг үүсгэдэг учраас банк зээлээ хязгаарладаг.


Санхүүгийн зуучлалын гүнзгийрэл

Долларжилтын нэг эерэг үр дагавар нь гадаад худалдааны зардлыг бууруулж, хөрөнгийн урсгалыг илүү нээлтэй болгосноор санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлж, эрүүл санхүүгийн системийн хөгжлийг дэмжиж болох талтай.

4. МОНГОЛ УЛСЫН ДОЛЛАРЖИЛТЫН ЯВЦ


Монгол улсын долларжилтын түвшин⁶ сүүлийн 10 жилийн турш ойролцоогоор 30-50 хувийн хооронд хэлбэлзэж байгаагаас харахад дундаж долларжсан орнуудын бүлэгт орж байна.

Зураг 1. Долларжилтын түвшин (хувиар)



Долларжилтын динамикийг харвал 2002-2006 он ба 2008-2009 оны дунд үе хүртэл өсөх трендтэй байна. (Зураг 1). 2000-2007 он хүртэлх хугацаанд инфляци долларжилттай эерэг пропорциональ хамааралтай байсан бол 2008 оноос хойш инфляци буурч эхэлсэн боловч долларжилтын түвшин өссөн хэвээр байна. Харин энэ хугацаанд төгрөгийн ханшийн сулралт нь долларжилттай илүү хамааралтай болсон байна (Зураг 2).

Зураг 2. Инфляци, нэрлэсэн ба бодит ханшийн өөрчлөлт




⁶ Гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх хувь

⁷ Patrica Alvarez-Plata and Alicia Garcha-Herrero, ADB, september 2007 pp

Манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр унаж, гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн, гадаад валютын орох урсгал багасч, гарах урсгал давамгайлснаар валютын эрэлт эрс өсч, улсын төсөв болон төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн үед ам.доллартай харьцах төгрөгийн нэрлэсэн ханш 2008 оны 4-р улирлаас 2009 оны 1-р улирал хүртэлх хугацаанд сулрах хандлагатай, нийгмийн сэтгэлзүй төгрөгийн ханш суларна гэсэн хүлээлттэй байсан нь гадаад валютын зохиомол эрэлт нэмэгдэн, долларжилтын түвшин өсөхөд хүргэсэн. Энэ хугацаанд гадаад валютын татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь 36.2%-иас 42.1%-д, гадаад валютаар олгосон зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 32.4%-иас 34.7%-д хүрч өссөн юм.

Зураг 3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн ба зээлийн долларжилт



Татан төвлөрүүлсэн хөрөнгийн болон зээлийн долларжилтын хоорондох хамаарлыг харвал татан төвлөрүүлсэн хөрөнгийн долларжилт 1.0 хувь өсөхөд зээлийн долларжилт ойролцоогоор 0.8 хувь өсөж байна.

5. ЭМПИРИК ХЭСЭГ

Энэ хэсэгт онолын таамаглалыг Монголын эдийн засгийн тоон өгөгдлүүд дээр шалгах эмпирик шинжилгээг хийнэ. Эмпирик шинжилгээнд Eduardo Levy Yeyati, Gianni De Nicolò, Padric Honohan, Alian Ize (2003) нарын судалгаандаа ашигласан VECM, TSLS загварыг суурь болгон ашиглах бөгөөд өөрийн орны онцлогыг тусгасан макро эдийн засгийн хувьсагчдыг оруулан загварыг байгуулсан.

5.1. Загвар

5.1.1. Коинтеграци шинжилгээ

Долларжилт болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хоорондох урт хугацааны хамаарлыг Johansen-ны коинтеграци шалгах тестийг ашиглан тодорхойлох болно.

Johansen-ны арга нь хувьсагчдын коинтеграци хамаарлын тоог тодорхойлохдоо 2 тест статистикийг ашигладаг. 1/. Trace тестээр Π матрицын рангыг шалгадаг буюу $\text{rank} \leq p$ гэсэн тэг таамаглалыг шалгадаг, энд r нь коинтеграци векторын тоо байна. 2/.

Maximum eigenvalue тест нь $1+r$ векторын коинтеграци векторын тоо r байна гэсэн тэг таамаглалыг шалгадаг. Энэхүү тест нь энгийн түвшинд (level) тогтворгүй time series өгөгдлүүдийн VAR загварын үнэлгээтэй адил байна. Үзүүлэлтүүдийн энгийн хэлбэрт үнэлэгдсэн коэффициентийн матриц нь тус загварын урт хугацааны шинж чанарын тухай мэдээллийг агуулна гэж үздэг.

A. Вектор алдаа залруулах загвар

Долларжилт болон түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хоорондох урт хугацааны хамаарлыг тодорхойлохдоо урт хугацааны тэнцвэрээс зөрөх богино хугацааны алдааг ялган харуулдаг вектор хэлбэрт алдаа залруулах загвар (VECM)- ыг ашигласан.

$$\Delta Y_t = \left(\sum_{i=1}^k \Phi_i \times \Delta Y_{t-i} \right) + A \times ecm_{t-1} + \sum_{j=0}^n (\Psi_j \times D_{t-j}) + \zeta_t$$

Үүнд:

$$Y_y = \begin{bmatrix} dr_t \\ mvp_t \\ rer_cyc_t \\ res_t \end{bmatrix} \text{-хувьсагчдын вектор, } D \text{-дамми хувьсагчид, } A \text{-алдааг залруулах}$$

коэффициентийн вектор, Φ ба Ψ - загварын коэффициентцуудын матриц, Δ -р эрэмбийн ялгаврын оператор, ζ_t - алдаа

Энд dr - долларжилт, mvp - портфель сонголт, rer_cyc - валютын ханш ба ДНБ-ий өсөлтийн хоорондох хамаарал, res -гадаад валютын нөөц, D – дамми хувьсагч

B. Хоёр алхамт хамгийн бага квадратын арга

Долларжилтын санхүүгийн зуучлалын гүнзгийрэл болон санхүүгийн системийн эмзэг байдалд үзүүлэх нөлөөг үнэлэхэд санхүүгийн зах зээлийн хөгжилд нөлөөлөх олон хүчин зүйлс нь мөн долларжилтанд нөлөөлж байдаг учраас endogeneity асуудалд анхаарах шаардалага гарч ирдэг. Тиймээс инструмент хувьсагчдыг оруулан TSLS-аргыг ашиглав.

$$mdept_l_t = mdepth_t(c, dr_l_t, dr \times inf_t, inf_t, fex_sa, i)$$

$$npl_l_t = Z_t(dr_t, infvol_t, rervol_t, corr(inf, rer)_t, i)$$

$$depvol_l_t = Z_t(dr_t, infvol_t, rervol_t, corr(inf, rer)_t, i)$$

Үүнд: $infvol$ - инфляцийн хэлбэлзэл, $rervol$ - бодит ханшийн хэлбэлзэл, $corr(inf, rer)$ -инфляци ба бодит ханшийн хоорондох хамаарал, dr -долларжилт, inf -инфляци, fex -засгийн газрын зардал i - инструмент хувьсагчид

5.2. Тоон өгөгдөл

Эмпирик шинжилгээнд 2001 оны 1 дүгээр сараас 2010 оны 3 дугаар сарын хоорондох тоон өгөгдлийг сарын давтамжтай ашигласан. Гадаад валютын нөөц, санхүүгийн зуучлалын гүнзгийрэл, чанаргүй зээл, депозитын хэлбэлзэл зэрэг үзүүлэлтүүд натурал логарифм хэлбэрээр орсон бөгөөд төсвийн зардлын тоон өгөгдөлд улирлын зохицуулалтыг Census X12 аргаар хийв. Тоон өгөгдлийг бэлтгэхдээ Монгол банк болон Үндэсний Статистикийн Хорооноос гаргадаг статистикийн сарын бюллетень зэрэг эх үүсвэрийг ашиглав.

Онолын үндэслэл болон бусад эмпирик судалгаануудын үр дүнд үндэслэн манай орны онцлогт тохирох дараах тоон өгөгдлүүдийг сонгосон (Хувьсагчдын тооцооллыг хавсралт 1.2-д харуулав). Үүнд:

Долларжилтыг тодорхойлох хувьсагчид

- Долларжилт/dr/ - долларжилтын түвшинг илэрхийлнэ.
- Хамгийн бага вариацийн портфелийн хувь /mvp/ - портфелийн загварыг шалгах зорилгоор макро эдийн засгийн хүчин зүйлийг төлөөлүүлж сонгосон. Энэ хувьсагч өсөх тусам долларжилт өснө гэж таамаглана.
- Валютын ханш ба ДНБ-ний өсөлтийн хамаарал /reg_cus/ - мөчлөгийн дагуу бодит ханш сулрах нь долларжилтыг өсгөдөг эсэхийг шалгах буюу зах зээлийн гажуудлыг төлөөлнө (Энэ нь онолын хэсэгт дурдсан ханш сулрах тусам өр төлөгдөхгүй байх магадлал өснө гэсэн таамаглалыг төлөөлөх юм.)
- Гадаад валютын нөөц /res/ - эдийн засгийн бодлогын итгэл үнэмшлийг төлөөлөх бөгөөд нөөцийн түвшин их байх нь долларжилтыг бууруулахад нөлөөлнө гэж таамаглана.
- Хуулийн хязгаарлалт /d_rest/ - гадаад валютын зах зээл дээрх зохицуулалт долларжилтанд чухал нөлөөтэй байдаг. “Монгол улсын нутаг дэвсгэр дээр төгрөгөөр төлбөр тооцоо хийх тухай” хууль батлагдсанаар долларжилтыг бууруулж байгаа эсэхийг шалгах зорилгоор 2009.07 сараас хойших хугацаанд улирлын бус дамми хувьсагч оруулсан. Загварт институцийн хүчин зүйлийг төлөөлөх ба долларжилтыг бууруулна гэж таамаглагдана.
- Улирлын дамми хувьсагчид /s(i)/ - долларжилтанд тухайн сарын нөлөө байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор улирлын дамми хувьсагчийг сараар оруулсан.

Санхүүгийн зуучлалын гүнзгийрлийг тодорхойлох хувьсагчид

- Санхүүгийн зуучлалын гүнзгийрлийн түвшин /mdepth/ - нийт мөнгийг ДНБ-д харьцуулсан харьцаагаар санхүүгийн зуучлалын гүнзгийрлийн түвшинг төлөөлөх бөгөөд авсан загварт хамаарах хувьсагчыг илэрхийлнэ.
- Инфляци /inf/, инфляци ба долларжилт /dr× inf/, Засгийн газрын зардал /fex/ - макро эдийн засгийн хүчин зүйлсийг төлөөлнө.
- Инструмент хувьсагчид /iv/ - долларжилтыг тайлбарлагч болон дамми хувьсагчдыг оруулсан.

Санхүүгийн системийн эрсдэлийг тодорхойлох хувьсагчид

- Чанаргүй зээлийн хувь /npl/ - санхүүгийн системийн төлбөрийн чадварын эрсдлийг төлөөлж хамаарах хувьсагчдаар орсон.
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийн хэлбэлзэл /devol/ - санхүүгийн системийн хөрвөх чадварын эрсдлийг төлөөлж хамаарах хувьсагчдаар орсон.
- Инфляцийн хэлбэлзэл /infvol/, бодит ханшийн хэлбэлзэл /regvol/, инфляци ба бодит ханшийн корреляци /corr_inf_reg/ - макро эдийн засгийн тогтворгүй байдлыг илэрхийлэх зорилгоор сонгосон.
- Инструмент хувьсагчид /iv/ - долларжилтыг тайлбарлагч болон дамми хувьсагчдыг оруулсан.

5.3. Үнэлгээний үр дүн

Интеграцийн зэрэг

Судалгаанд ашиглаж буй үзүүлэлтүүдийн тогтвортой эсэхийг ADF тестээр шалгаж, үр дүнг хүснэгт хавсралт 1.3 –д харуулав.

Нэгж язгуурын ADF тестийн үр дүнгээс харахад тэг таамаглалыг няцааж чадахгүй буюу бүх хувьсагчид тогтворгүй байгаа тул I(1) процесс байна. Иймээс долларжилт болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хооронд урт хугацааны хамаарал оршин байгаа эсэхийг шалгах коинтеграци шинжилгээг хийх боломжтой болж байна.

Коинтеграци шинжилгээ

Хүснэгт 1. Johansen коинтеграци тест

H0 таамагла	Maximal eigenvalue		Trace	
	Max-Eigen статистик	Критик утга (0.05)	Trace статистик	Критик утга (0.05)
$r=0$	48.7*	28.6	84.4*	54.1
$r \leq 1$	28.4*	22.3	35.7*	35.2
$r \leq 2$	4.7	15.9	7.3	20.3

*5%-ийн ач холбогдлын түвшинд H0 таамаглалыг няцаана.

Johansen-ны тестээс харахад хувьсагчдын хооронд коинтеграци байхгүй гэсэн тэг таамаглал maximal eigenvalue statistics ба trace statistics-ийн аль алинд нь хүчтэй няцаагдаж байна. Trace статистик болон Max-Eigen статистик нь эдгээр хувьсагчдын хооронд боломжит 2 коинтеграци хамаарал байж болохыг харуулж байна. (Хавсралт 2.1) Эдгээрээс 1 коинтеграци векторыг тодорхойлох зорилгоор VEC загварыг үнэлэв.

Вектор алдаа залруулах загвар (VECM)-ын үр дүн

VAR загварын хугацааны оновчтой хоцролтыг Akaike болон Lag Exclusion Wald Test -ээр 12 болохыг тодорхойлсон (Хавсралт 2.2) учраас VECM-ын хугацааны хоцролтыг 11-ээр сонгосон. VEC(11) загварт экзоген хувьсагчаар улирлын ба улирлын бус дамми хувьсагчдыг оруулсан бөгөөд урт хугацааны коинтеграци хамаарлын коэффициентүүдийг тодорхойлсон үр дүнг дор харуулав. Тэгшитгэлийн үлдэгдлүүдийн диагностик тестүүдийн үр дүн нь 5%-ийн ач холбогдлын түвшинд үлдэгдлүүд хэвийн тархалттай, серийн кореляцигүй, хетероскедасити алдаа байхгүй болохыг харуулсан. (Хавсралт 2.3-2.5)

Долларжилт ба түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн урт хугацааны хамаарлын тэгшитгэл:

$dr =$	-0.31	$+0.11 * mvp$	$+0.26 * rer_cyc$	$-0.06 * res_l(-1)$
s.e	(0.04)	(0.05)	(0.09)	(0.01)
t.stat	[-6.91]	[-2.03]	[-2.76]	[4.41]

Үнэлгээний үр дүнгээс харахад:

- MVP буюу инфляци ба бодит валютын ханшийн харьцангуй хэлбэлзэл 10% - иар өсөхөд долларжилт 1.1%-иар өсдөг байна.
- Бодит валютын ханшийн өөрчлөлт ба бодит ДНБ-ний өсөлтийн хоорондох корреляци 10%-иар өсөхөд долларжилт 2.6 %-иар өсдөг байна.
- Гадаад валютын цэвэр албан нөөцийн ДНБ-харьцуулсан харьцааны өсөлт 10%-иар нэмэгдэхэд долларжилтыг 0.6 %-иар бууруулдаг байна.

Энэ нь багцын онол, зах зээлийн гажуудал, бодлогын итгэл үнэмшлийн долларжилтанд үзүүлэх нөлөөг тайлбарласан онолын таамаглалтай нийцтэй гарч байна.

TSLS (2 алхамт ХБКА) загварын үр дүн

Долларжилтын санхүүгийн зуучлалын гүнзгийрэл ба системийн тогтворгүй байдалд үзүүлэх нөлөөг шалгасан үнэлгээний үр дүнг хүснэгт 2-д харуулав. Үлдэгдлийн диагностик тестүүд болон инструмент хувьсагчдыг зөв тодорхойлогдсон эсэхийг шалгах тестүүдийг хавсралт 3-д харуулав.

Хүснэгт 2. Долларжилтын эдийн засагт үзүүлэх нөлөө

Тайлбарлагч хувьсагчид	Санхүүгийн зуучлалын гүнзгийрэлд үзүүлэх нөлөө	Чанаргүй зээлийн хувьд үзүүлэх нөлөө	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтийн хэлбэлзэлд үзүүлэх нөлөө
c	1.87	-0.3	
dr	-0.46	0.01	0.03
infvol	-	0.07	0.12
rervol(-1)	-	-0.001	0.05
corr(inf,rer)	-	-0.07	1.02
dr*inf	0.13	-	-
inf	-0.05	-	-
fex_sa	4.36E-06	-	-
R ²	0.98	0.98	0.74
Adj R ²	0.98	0.98	0.73

-Хамаарах хувьсагч: log(mdepth) log(npl_l) log(depvol)

-Инструмент: c, idif, dum_r, dum_0811, s1, s2, s10, s12, rer_cyc, mvp

Үнэлгээний үр дүнгээс харахад долларжилт 1%-иар өсөхөд:

- Чанаргүй зээлийн өсөлт 0.01 нэгжээр,
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэлбэлзлийн өсөлт 0.03 нэгжээр тус тус нэмэгдэж,
- Санхүүгийн зуучлалын гүнзгийрлийн түвшин 0.46 нэгжээр буурч байна. Харин инфляцитай үед санхүүгийн зуучлалын гүнзгийрлийг 0.13 нэгжээр өсгөж байна. Инфляци ба долларжилтын хооронд хүчтэй эерэг хамаарал

байгаа нь инфляцийн санхүүгийн зуучлалд үзүүлэх сөрөг нөлөөллийг долларжилт зөөлрүүлж байна.

Энэ үр дүн нь долларжилт санхүүгийн системийн тогтворгүй байдлыг бий болгоход нөлөөлдөг гэсэн онолын таамаглалтай нийцтэй гарч байна.

5. ДҮГНЭЛТ

Эмпирик шинжилгээний үр дүнгээс харахад Монголын эдийн засаг дахь долларжих үйл явц нь макро эдийн засгийн тогтворгүй байдал зах зээлийн гажуудал болон институцийн чанараас хамаардаг гэсэн онолын таамаглалтай нийцтэй гарлаа.

Долларжилтыг тайлбарлах хүчин зүйлсийг тодорхойлох:

